

“БҮШИДО” ЁС ЗҮЙН СУРГААЛ

М.Золзаяа- Монгол Улсын ШУА. ФСЭХ-ийн ЭША, доктор

Товч утга: Энэхүү өгүүлэлд Япон үндэстний бахархал болсон самуурайн ёс горим буюу “бүшидо” Японы ёс зүйд ямар байр суурь эзэлдэгийг товч авч үзлээ. Бүшидо нь дорно дахины орнуудын ёс зүйн сургаалын хэлхээ холбоо ба япончуудын ертөнцийг үзэх үзэл, ёс суртахууны үнэлэмжийн онцлогийг тодруулах нэгэн сурвалж юм.

Түлхүүр үг: бүшидо, самуурай, шинто, зэн буддизм, харакири, сэппүкү, Акоо овог, shinjuu

Өнө эртний түүх, соёлтой Японы “бүшидо” нь ёс зүй судлаачдын сонирхлыг татсан сэдвийн нэг бөгөөд энэ талаар олон арван судалгаа шинжилгээ, урлагийн бүтээлүүд бий. Эдгээрээс дэлхийн өнцөг булан бүрт хүрч уншигчдын талархалыг хүлээсэн нэгэн бүтээлийг Японы нэрт эрдэмтэн, нийгмийн зүтгэлтэн Нитобэ Иназо /1862-1933/ туурвижээ. Тэрээр өрнөдийнхөнд зориулж, анх удаа англи хэлээр 1899 онд “Бүшидо” номоо бичсэн.²⁴ Уг номонд бүшидогийн уг гарваль, ёс горим, нийгэмд үзүүлсэн нөлөө, самуурайн хүмүүжил төлөвшлийг шашин, ёс зүй, философийн үүднээс үндэслэн тайлбарлажээ. Түүнчлэн тэр үеийн /XIX зуун/ Японы нийгмийн ёс суртахуунгүй үзэгдлийг шүүмжлэн, ёс зүйн түүхээ эргэн харахыг анхааруулахын зэрэгцээ христос шашныг дэлгэрүүлэгчид угсаатны ёс зүйн оцлогийг судлан үзэх шаардлагатайг өгүүлжээ. Энэ ном нь Японы нэрт дипломатч Хатано Ёшиогийн хэлсэнчлэн, даяаршлын үед япончууд дэлхий дахинд өөрийгөө таниулах арга ухааныг суралцах төдийгүй дахин нэг тунгаан бодож үзвээс зохистой бүтээл юм.

Японы ёс зүй нь Күнзийн сургаал, зэн буддизм, шинтоизмийн үзэл сургаалд үндэслэдэг болохыг олон арван судлаачид тэмдэглэжээ. Чухамдаа япончууд эдгээрийг хэрхэн өөриймсүүлж, баяжуулан хөгжүүлсэн бэ? гэдэг асуултын хариулт нь тэдний ёс суртахууны сургаалд байна. Онцлон хэлбэл, бидний өгүүлэх гэж буй “бүшидо” мөн. Бүшидо нь бүши-самуурай, цэрэг, дайчин нарын ажил амьдралдаа мөрдөх, до-зарчим, зам мөр, арга ёс гэсэн утгатай хоёр үгнээс бүтнэ. Энэ нь X-XI зууны үеийн цэрэг-феодалын Японд газар хувийн эзэмшилд шилжих явцад үүссэн гэж үздэг. Феодалын харилцаа тогтоход тусгай нэг эзэмшил газраа хамгаалах хүчирхэг бүши нар буюу **самуурай** анги бий болжээ. Мөн самуурайн гүйцэтгэх үйл хэрэг түүний шалгуур, шагнал урамшил, ёс суртахууны хариуцлагын хэрэгцээ аяндаа бий болсон. Тэднийг тэргүүлэгч **эзэн ноён нь** самуурайн гэр бүл хийгээд харъяатуудынхаа өмнө өндөр хариуцлага хүлээнэ. Самуурай нарын ёс горимыг **бүшидо** гэж нэрлэдэг байна. Энэ нь албан ёсоор тогтоогоогүй ч өнөөгийн ойлголтоор бол самуурайн ёс зүйн дүрэм байжээ. Улмаар дээд анги давхаргын гэдэг утгаараа нийгмийн ёс суртахууны харилцаанд гол байр суурьтай. Энэ нь Японы соёлд амнаас ам дамжин заавал дагаж мөрдөх ёстой хэв хууль, ёс суртахууны хэм хэмжээ болон тогтжээ.

Бидний үзэж буйгаар бүшидогийн гол агуулга нь: бусдад шударгаар захирагдах ёс буюу өөрийн эзэн ноёндөө үнэнч шударгаар үйлчлэх, үүргээ нэр төртэй биелүүлэх, өөрийн ойр шадар хүмүүсийн сайн сайхны төлөө тэмцэх, тэвчээртэй байх зэрэг юм. Харин эзэн ноён бусад самуурайн бүлгийн хооронд

²⁴ Нитобэ Иназо. Бүшидо Япон үндэстний ёс зүйн цогц. УБ., 2007

зорчил үүсвэл амь насаа үл хайрлан урвалтгүйгээр өөрийн талаа хамгаалж өшөө авах үүрэгтэй.

Үүргээ биелүүлж чадаагүй самуурай нэр төрөө гутахаас зайлсхийж, олны өмнө сэлпүкү хийн үнэнч шударгаа нотловол ял гэмээс цагаатгасанд тооцдог. Үүнийг "ХАРАКИРИ /сэлпүкү, каппүкү/ буюу хэвлийгээ хага татах гэсэн утгатай үг" гэж нэрлэнэ. Энэ нь Япончууд эртнээс биеийн хэвлийн хэсэгт сүнс оршдог хэмээн үздэгтэй холбоотой бөгөөд самуурай өөрийн гараар ёслолыг гүйцэтгэдэг байна. Хэдий чинээ зовлон бэрхшээл амсана төдий чинээ амьдралаас түргэн ангижрах ёстой гэж тэд үздэг. Уг ёслолд овгийн жирийн иргэд гэрч болно. Өөрийнхөө шударга чанарыг олны өмнө ил тод нээлттэй үзүүлэх нь нэг талаар урваж шарвахгүй, туйлбартай, үнэнч байхыг бишрэн дээдлэхэд хүргэдэг ажээ. Нөгөө талаар жирийн хүмүүст амьдралын явцад туулах бэрхшээл зовлон, гутрал гуниглалаас болж амиа хорлохгүй байхыг сэрэмжлүүлэхэд оршино.

Эзэн ноёны сайн нэр, үйл хэргийг нотлох үүргээс үл буцах эсвэл түүнийг бусдад дарлуулахад өшөө авах гэх мэт бушидогийн хатуу чанга ёсууд бий. Нэгэнт самуурай өөрийн үүргийг нэр төртэйгөөр биелүүлээгүй бол ажилгүй, амь зуулгын аргагүй болж, амьд явахад ч хэцүү бэрх зовлонг туулахад хүрдэг. Иймээс тэд ёс горимоо ч чандлан сахидаг байна.

Бүшидо дахь ёс суртахууны ойлголт нь **нэр төр, тэсвэр хатуужил, үнэнч байх** зэрэг юм. Самуурайн зан төлөвийг тогтворжуулахад бага наснаас нь анхаарах бөгөөд уран зохиолын мэдлэг, ёс суртахууны сургаалыг голлон судлуулдаг ажээ.

Бүшидод самуурайн хориглон цээрлэх зүйлс нь: эр зориггүй байх, ёс горимыг зөрчих, бүх төрлийн худалдаа хийх, зугаа цэнгээн, мөрийтэй тоглоом, эд мөнгөнд шунах, өчүүхэн зүйлд уурсах зэрэг болно. Эдгээр ёс горим нь японы ёс зүйн сургаалын нэн чухал хэсэг болтлоо дэлгэрсэн юм.

Японы ёс зүй нь шинтоизм, Күнзийн сургаал, зэн буддизмийн үзэл сургаалтай салшгүй холбоотой тул тодруулан авч үзэх нь чухалтай юм. Японы шүтлэг бишрэлд уугуул шашин нь болсон шинто, VI зууны үе буюу Нарагийн үеэс /710-794/ Энэтхэгээс Хятад, Солонгосоор дамжин орж ирсэн буддын шашин, христосын шашин зонхилох байрыг эзлэнэ. Үндэсний шинто шашинд ёс заншлаа нарийн чанд дагаж мөрдөх, өвөг дээдсийн сүнс шүтэхийг гол болгодог нь бүшидод эзэн ноёндoo үнэнч үйлчлэх үүрэг гэдэг утгаар тогтсон гэлтэй. Бүшидог баримтлагчид эзний нэр төрийг унагаасан этгээдтэй тэмцэх нь миний гол үүрэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл, нийгэмд эзлэж буй байр суурь, нэр төрөө хамгаалж сайн үйл бүтээхийн учрыг ухамсарлахад өвөг дээдсийн шүтлэг нь нөлөөлжээ. Шинто шашны оршин суугаа газар усны ками, лус тахих ёслол, цагаан будааны сүнс дуудах зэрэг байгалиа дээдлэх зан үйлүүд нь бүшидод эх орноо хайрлах үзлийг суулгасан гэж болно.

Күнзийн ёс зүйн синь /үнэнч шударга/, чүн /сурахад бие сэтгэлээ зориулах/, сэн /амьдралын идэвхитэй байр суурийг судлах/, вэн /судар бичгийг судлах/ гэсэн зарчим ба "шударга байна гэдэг нь сэтгэлээ нэг болгохыг хэлнэ"²⁵ гэдэг сургаал басхүү бүшидод шингэжээ. Хаан хүн хааны ёсоор, сайд хүн сайдын ёсоор, эцэг эцгийн ёсоор, хүү нь хүүгийн ёсоор байвал зохино хэмээх хүн бүр хариуцлагатай нэр төртэй байхын ута учрыг японы самуурай нар жинхэнээр нь хэрэгжүүлж байжээ. Тиймээс эзнийхээ удирдан чиглүүлж байгаа үлгэр дууриалыг үг дуугүй дагадаг. Хятадын философич Мэн-зийн "Эцэг хүү хоёр бие биеэ хайрлах ёстой. Эзэн харъяат хоёр бие биедээ шударга байх ёстой"²⁶ гэж сургасан нь бүшидод нийцэн зохицсон байна.

²⁵ Күнз. Шүүмжлэл өгүүлэл. УБ., 2004, Шударга ном. УБ., 2004

²⁶ Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. УБ., 2003. 73 дахь тал.

Японд Күүкай /774-835/, Эй сай /1141-1215/, Хоонэн /1133-1212/, Доогэн /1200-1253/ нарын сэтгэгчид зэн буддизм дэлгэрэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Эй сай 1184 онд чань буддизмын сүм дугана барьж байгуулахад, төд удалгүй самуурайн анги давхаргынхан хүлээж авчээ.²⁷ Зэн буддизмын сото урсгал нь ертөнцийн мөн чанар хоосон чанартай гэж үзээд, даяан хийж гэгээрэлд хүрэхийг номлодог. Сото-зэн урсгалыг дэлгэрүүлсэн Доогэн “даяан гэдэг бол хүлцэн тэвчих үйлийн арга” хэмээн сургажээ. Үхэх, амьдрах, жаргах цэнгэх зэрэгт ач холбогдол өгч сэтгэл хөдлөлөөр хандах нь утгагүй, энэ бол амьдралын бодит мөн чанар гэж сургадаг нь бүшидод тусгалаа олжээ. Өөрөөр хэлбэл, амьдрал, үхэл хоёрын мөн чанар адил гэдгийг хүлээн зөвшөөрөх нь бүши нарын төлөвшилд юунаас ч чухал.

Самуурайн ёс горимын гол хүч нь “Хагакурэ” омгийн Набэсима Ямамото Цунэтомогийн харъяат нартаа айлдсан *“Би тамд байна. Тэнгэр намайг гэсгээнэ. Гэвч хэн ч, юу ч надад эзнийхээ хүсэл зоригийг биелүүлэхэд саад болох ёсгүй”* гэдэг уриа юм. Үүнээс үзвэл харакири хийхийг тэнгэрийн гэсгээл гэж үздэгийг харуулна. Мөн Эдо эриний /1600-1867/ доасизмийг баримтлагч Ямага Соко /1622-1685/ “сидо” сургаалдаа хүн бол үхэх төрөх гэдэг хөдөлгөөнд оршдог учраас 1/ эзэндээ үнэнчээ нотлох, 2/ нэр төртэй үхэх, гэхдээ 3/ амьдралын мөч бүрийг хайрлах ёсыг²⁸ номлосон буйг дурьдах нь зүйтэй.

Одоогоос 305 жилийн өмнө Акоо овгийн эзэн самуурай Асоно Нагонори Шёогүний ордны журам зөрчин ёслол хариуцагч Кира Ёшинакаг шархдуулсан. Асоногийн харъяат самуурай нар эзэн ноёныхоо өшөөг авч Кирагийн амийг егүүтгэжээ. 1703.02.04-д Акоо овгийн самуурай нарт эзнийхээ адил харакири хийж амиа егүүтгэх тушаал ирж, тэд харакири хийцгээжээ. Ингэж Акоо овгийн самуурай нар олон зуун жил дагаж ирсэн ёс горимын дагуу үнэнч чанараа илтгэсэн аж. Эдгээр 47 самуурай эзэн ноён Асоногийн сайн нэрийг сэргээхийн төлөө амь хайргүй тэмцсэн домогт түүх эдүгээ ч япончуудын дунд хэлэлцэгдэж, үнэнчээр, эрэлхэг зоригтой тэмцэх, шударга хөдөлмөрлөхийн үлгэр дууриал болсоор байна. Тэдний үнэнч шударга шийдвэрийг орчин үеийн япончуудын дийлэнх нь зөв зүйтэй алхам гэж үздэг байна.²⁹

Бүшидог номлогч багш Ямамото Цунэтомо гэгч дүгнэхдээ: *“Акоо овгийн шийтгэл нь хувийн амжилтандаа хэдий их санаа зовно төдий чинээ үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэсний шинж. Тэдний үйлдэл хүслээ биелүүлэхэд ямар их сэтгэлзүйн бэлтгэл хэрэгтэйг харуулж байна. Тэртээ тэргүй хоёр жилийн дайн болвол тэдгээр самуураинууд ямар нэг шалтгаанаар үхэх байсан. Акоо овгийн эзэн ноён тэдэнд цусаар ариутгах боломжийг бүрдүүлжээ”* хэмээжээ. Түүнтэй ижил төсөөтэй санал эдүгээ ч япончуудын дунд олонхи ба тэрхүү 47 самуурайд толгой гудайлган хүндэтгэл үзүүлсээр байгаа юм. Тэгэхээр сэлпүкү буюу хэвлийгээрээ амиа егүүтгэх нь эмгэнэлтэй боловч нэр төртэй үхэлд тооцогдож байжээ.

Самуурай нарын “тэмцэж буй хүнд үхэл ойрхон” гэдэг зарчимтай холбоотой байж болох нэг ёс заншил бол shinjuu юм. Эдогийн эхэн үед хосууд хайрынхаа илэрхийлэл болгож нэгнийхээ үсийг хайчлан тангараг тавьцгаах ёсыг shinjuu гэдэг байсан. Мөн Shinjuu-г дурсан шивээс хийдэг. Эдогийн сүүлийн хагаст хосууд хайр сэтгэлийнхээ төлөө тэмцэж, амиа хорлохыг Shinjuu гэж нэрлэн ба хосуудын хайрын дээд биелэл гэдэг³⁰ бэлгэдлээр тайлбарладаг

²⁷ Мел Томпсон. Восточная философия. М., 2001. с.330

²⁸ М.Эгучи. Бушидо. -Этика. Энциклопедический словарь. М., 2001

²⁹ Д.Төмөрбаатар. Чюүшингүра ба орчин үеийн япончууд -Японы соёл: уламжлал, шинэчлэл. УБ., 2008. 86 дахь тал

³⁰ Japan as it is. Published Gakken. Printed in Japan. Fourt edition 2002. p.35

байжээ. Эндээс үзвэл бүшидо ёс горим нь түүхийн явцад хувьсан өөрчлөгдсөөр өнөө үед иржээ.

Судлаачид орчин үеийн япончуудын ёс суртахууны үнэлэмжид бүшидо ёс горимын онцлог шинжүүд илэрч байна гэж дүгнэдэг. Эзэн ноёндoo үнэнч байх нь бүшидо дахь эн тэргүүний үүрэг байсан бол, орчин үеийн японы жирийн албан хаагчид хэдий чинээ үнэнч, нягт нямбай, идэвхитэй хөдөлмөрлөж үүргээ биелүүлнэ төдий чинээ чөлөөт цаг гарч, гэр бүлийн сайн сайхан амьдрал бэлэн болдог гэж үздэг. Япончууд аливаа үйлдлээс ашиг олох зорилт тавьж ажилладаг нь тэднийг “эдийн засагч /ашигч/ амьтад” гэж үзэхэд хүргэсэн байдаг. Гэвч ашгийн сэдэл нь амжилттай хөдөлмөрлөхөд нөлөөлдөг шүү дээ. Харин үйлдвэрийн удирдлага өөрийн ажиллагсдын нийгэм хамгаалал, нэг насны амьдралын төлөө зүтгэх үүргээ ухамсарладаг нь самуурайн эзэн ноёнтон адил юм. Ёс суртахууны хүмүүжлийн ийм уламжлалт арга барил нь Японы нийгэм эдийн засгийн хөгжилд гол хүчин зүйл болсон байна. Тэдний нийгэм, эдийн засгийн өсөлт, амжилтын үндэс нь бүшидогоос эхтэй ёс суртахууны хэм хэмжээ, зарчмууд гэж үзэж болно. Тухайлбал, дараахи нийтлэг сайн чанарууд ажиглагддаг.

- Амьдралын хэв маяг, төрт ёсондоо уламжлалт түүх, ёс заншлын ололтыг авах гээхийн ухаанаар хандан хэрэгжүүлдэг. Бүшидог өнөө хүртэл амь бөхтэй оршиход япончуудын өвөг дээдсийн шүтлэг нь ихээхэн нөлөөлжээ.

- Аливаа асуудлыг эхнээс нь нягт нямбай боловсруулдаг одоо л энэ зөв зүйтэй арга зам мөн гэж итгэл, үнэмшилтэй болохоороо шийдвэрээ гаргадаг. Шийдвэрээ хэрэгжүүлэхийн тулд туйлбартай, эцсийг нь хүртэл шургуу хөдөлмөрлөж заавал биелүүлдэг ба эрсдлээ зөв тооцдог зан чанартай.

- Өөрсдийн ажил үйлсээ ёс заншил, ёс горимдоо тохируулан бие даан сайн зохицуулж чаддаг. Аливаа юмыг хамгийн багаас нь эхлэн дэс дараатай уйгагүй хийж сурдаг.

- Хувь хүн өөртөө өндөр хариуцлага оноож, нэр төрөө сэвтэхээс ихэд болгоомжилдог. Хэрвээ ажил үүргээ нэр төртэй биелүүлээгүй аваас буруугаа хүлээх, шийтгэл сонсох сэтгэлзүйн бэлтгэлтэй байж чаддаг.

- Нийгэмдээ, гэр бүлдээ, өөртөө тус нэмэр оруулах идэвхи санаачилга, ажилсаг, бүтээлч зан чанар төлөвшсөн зэргийг дурьдаж болно. Иймээс ч ёс заншлаа умартсан, ёс суртахуунгүй үйлдлийг бүшидогүй эсвэл бүшидо алдагдлаа гэх мэтээр буруушаах үнэлэмж эдүгээ ч бий.

1868 онд самуурайн анги давхарга албан ёсоор халагдахад хүмүүс бүшидог хуучин хоцрогдсонд тооцох болсон. Гэвч бүшидо нь Японы ёс зүйн амин сүнс, чиглүүлэгч—үзэл, загвар болсоор буйг олон судлаач нолтон өгүүлжээ. “Дэлхийн хоёрдугаар дайн Японы бүхий л материаллаг зүйлсийг устгасан. Эндээс зөвхөн хүмүүс л үлдсэн” юм хэмээх үгийн нэгэн учир холбогдол чухамхүү бүшидод орших бөлгөө.

Ном зүй

1. Зэн буддизм: Амьдралаас ангижрахуй. УБ.,2002
2. Мел Томпсон. Восточная философия. М.,2001
3. Т.Намжил. Япон орон. УБ.,1999
4. Нитобэ Иназо. Бүшидо. Япон үндэстний ёс зүйн цогц. /Орч Д.Төмөрбаатар/ УБ.,2007
5. Japan as it is. Published Gakken. Printed in Japan. Fourt edition 2002.
6. Этика. Энциклопедический словарь. М.,2001
7. Японы соёл: Уламжлал шинэчлэл. УБ.,2008
8. Фэн Ю-Лань. Хятадын философийн товч түүх. УБ.,2003